



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1,2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр нийт 788.8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Алтанцэцэгт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын тайланда дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан Контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

2.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авч эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэдэг зөрчлийг давтан гаргахгүй байх, эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлийг үндэслэн залруулах;

2.4. Гэрээний эрх зүйн үндэслэл, заалтуудыг хууль тогтоомжид нийцүүлэх, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, биелэлтийг тооцож холбогдох буруутай этгээдээс гэрээнд заасан торгууль, алданги тооцож авах замаар байгууллагыг хохиролгүй болгодог тогтолцоог хэвшүүлэх;

2.5. Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланда авлагаар бүртгэсэн, техник хяналтын ажлын үлдэгдэл төлбөр 170.0 сая төгрөгийг "И Эс Би Солар Энержи" ХХК-иас нэхэмжлэн авах, тоног төхөөрөмжийг нийлүүлэгч талд буцаан өгөх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

132001219

2.6. Шалгалтын тайланд дурдсан 3 хуулийн этгээдтэй байгуулсан гэрээт ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн үлдэгдэл 79.6 мянган ам.долларыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах, гэрээнд заасны дагуу торгууль, алданги тооцох ажиллагааг зохион байгуулах, хугацаандаа хийгдээгүй ажлын зайлшгүй нөхцөл шалтгааныг үндэслэлтэй тогтоож буруутай ажилтан, албан тушаалтанд хариуцлага тооцох;

2.7. Худалдаан авах ажиллагааид “Төрийн болои орои шүтгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.8. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-д нийцүүлэн 2021 оны 03 дугаар улиралд багтаан батлах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчит бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.9. Тогтоолын биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр анхаарч ажиллах.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Ц.Түвшинзаяа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
298 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

| Д/д | Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга | Үнийн дүн сая.төг, мян.доллар | Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ |
|-----|---|-------------------------------------|---|
| 1 | Төлөвлөгөөгүй зардлыг санхүүжүүлсэн | 103.2 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг мөрдөн ажиллах |
| 2 | Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийг хангаж ажиллаагүй | - | |
| 3 | Гэрээт ажлын гүйцэтгэл болон санхүүжилтийг тооцоо нийлж, актаар баталгаажулаагүй | 198.7 /79.6 мянян. ам.доллар/ | Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг мөрдөн ажиллах |
| 4 | Ниссан Патрол Y62 маркийн улсын 61-89 УНА дугаартай тээврийн хэрэгслийг үйлдвэрийн газрын нэр дээр шилжүүлээгүй, Тоёота Чейзер маркийн улсын 37-45 УНГ дугаартай тээврийг хэрэгслийн нэрийг худалдан авсан хуулийн этгээдийн нэр руу шилжүүлээгүй | - | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах шилжүүлэх журам"-ыг мөрдөн ажиллах |
| 5 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны "Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах, худалдах зөвшөөрөл олгох тухай" 131 дүгээр тогтоолоор акталж, данснаас хассан хөрөнгөд устгалын акт үйлдээгүй | 318.6 | |
| 6 | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороонд байрлах 0.5 га өмчлөх эрхийн газар, Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3 дугаар хороонд байрлах 2.7 га эзэмших эрхийн газрыг үнэлж, санхүүгийн тайландаа туслагаагүй | 3.2 га | Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах |
| 7 | Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэн, орлогоос Улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн | 32.5 | Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах |
| 8 | Батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс гадуур зөвлөхийн үйлчилгээ | 68.2 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Сангийн |

| | | | |
|---------------------------|---|--------|---|
| | болон үндсэн хөрөнгө худалдан авсан | | сайдын 2018 оны 261 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайллагнах журам"-ыг мөрдөн ажиллах |
| 9 | Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа жишиг баримт бичгийг буруу сонгосон | 20.9 | |
| 10 | Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур зовшооролгүй хөрөнгө бэлтгэсэн | 2.4 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах шилжүүлэх журам"-ын 3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авх тухай хуулийн 48 дугаар зүйлийг мөрдөн ажиллах |
| 11 | Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэсэн /хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн/ | 44.3 | |
| Нийт дүн /мөнгөн дүнгээр/ | | 788.8 | |
| Нийт дүн /га газраар/ | | 3.2 га | |